



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 1146

Хархорин сум

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай  
тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн “Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай” А/96 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны 04 дугаар сарын 02-ний өдрийн “Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай” А/248 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Нарийн хүр, Онгоцон ухаа, Жалбаа, Шанх багийн 17,5 мянган га бэлчээрт микробиологийн аргаар хөнөөлт мэрэгчтэй тэмцэх ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 04 -ний өдрөөс эхлэн 7 хоногийн хугацаанд зохион явуулсугай.

2. Мэрэгч устгал зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, зарцуулагдах шатахуун, хөдөлмөр хамгааллын зардлыг 2 дугаар, хөдөлмөрийн хөлсний зардалыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Нарийн хүр багийн Шар бондгор, Талын дөрвөлжин, Зүүн намаг, Онгоцон ухаа багийн Хөгшин гол дагуу, Цагаан нуур, Наадмын дэнж, Азарын дээрс, Туркийн замын хойд урд тал, Урт богино хамар, Дөрвөлжин, Мөрөгцөг, Улаан худаг, Худаг элстий, Ар элстий, Жалбаа багийн Овоот, Тасархай, Тариат, Булашт, Өвөр хадат, Дэл, Сарын гол, Ар хадат, Цагаан нуур, Өвөр элстий, Шанх багийн Шар бүрд, Хүрэн ширэх, Бумбат, Дэрсэн худаг орчмын бэлчээрийг 2024 оны 04 дүгээр сарын 04 -ны өдрөөс эхлэн 15 хоногийн хугацаанд чөлөөлж, бэлчээрт мал оруулахгүй байхыг 4, 5, 6, 7 дугаар багийн Засаг дарга, малчдад үүрэг болгосугай.

4. Микробиологийн аргаар мэрэгчтэй тэмцэх ажлыг баг тус бүрийн ажил хайгч иргэн, малчдаар гүйцэтгүүлж, удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Лхагвасүрэн)-д даалгасугай.

5. Мэрэгчтэй тэмцэх ажлын явц, үр дүн, чанарт байнгын хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Ц.Баатарсүрэн)-д даалгасугай.

6. Хөдөлмөр хамгаалын хувцас, багаж хэрэгсэл, хоол хүнс, ажиллах хүчиний зардлыг Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (О.Гангаацэрэн)-д зөвшөөрсүгэй.



Хархорин сумын Засаг даргын 2024 оны  
11 дугаар сарын 08-ны өдрийн 14:00 дугаар  
захирамжийн 11 дугаар хавсралт

### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Б.Лхагвасүрэн (Засаг даргын орлогч )  
Гишүүдэд: Ч.Баттулга (Газрын даамал)  
мэргэжилтэн) Э.Үүрцайх (Мал аж ахуйн асуудал хариуцсан  
Э.Очир-Эрдэнэ (Архитектор)  
Н.Төгөлдөр (Байгаль хамгаалагч)  
Г.Отгонбаяр (Нарийн хүр багийн Засаг дарга)  
Б.Ганхуяг (Онгоцон ухаа багийн Засаг дарга)  
Л.Төгөлдөр(Жалбаа багийн Засаг дарга)  
О.Батсүх (Шанх багийн Засаг дарга )  
Нарийн бичгийн дарга: С.Мөнхсоёл (Бэлчээр, газар тариалангийн асуудал  
хариуцсан мэргэжилтэн)

Хархорин сумын Засаг даргын 2024 оны  
дугаар сарын 2-ны өдрийн 1.....дугаар  
захирамжийн 2-дугаар хавсралт

ШАТАХУУНЫ ХУВААРЬ

д/д	Багийн дугаар	Явах чиглэл, газрын нэр	Явах км	Зарцуулах шатахуун		Мөнгөн дүн
				АИ-92 үнэ-2530	ДТ үнэ-3740	
1	4	Шар бондгор, Талын дөрвөлжин, Зүүн намаг	450	-	110	411400
2	5	Хөгшин гол дагуу, Цагаан нуур, Наадмын дэнж, Азарын дээрс, Туркийн замын хойд урд тал, Урт богино хамар, Дөрвөлжин, Мөрөгцөг, Улаан худаг, Худаг элстий, Ар элстий,	550	40	60	325600
3	6	Овоот, Тасархай, Тариат, Булашт, Өвөр хадат, Дэл, Сарын гол, Ар хадат, Цагаан нуур, Өвөр элстий	600	70	80	476300
4	7	Шар бүрд, Хүрэн ширэх, Бумбат, Дээрсэн худаг,	500	60	60	376200
6	Хяналтын шатахуун		1500	400		1012000
7	Хөдөлмөр хамгаалал					960000
8	Хоол хүнс					1182100
НИЙТ ДҮН				860		4743600

--оо--

Хархорин сумын Засаг даргын 2024 оны  
07 дугаар сарын 08-ны өдрийн 11:00 дугаар  
захирамжийн 3 дугаар хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛСНИЙ ЗАРДАЛ

№	Ажил үйлчилгээ	Ажиллах хоног	Ажиллах хүн хүчний тоо	Өдрийн цалин	Нийт
1	Бэлчээрт микробиологын бэлдмэл цацах	4	30	40,000	4,800,000
	Нийт дүн				<b>4,800,000</b>

--оо--